

Бага сургуулийн 1-р ангид элсэлт авч байна



Ковид19-ийн нөхцөл байдлаас болоод элсэлт хүүхдүүдийн оролцоогүйгээр явагдах бөгөөд мөн боломжтой бол хууль ёсны асран хамгаалагч (эцэг эх) нартай үүлзахгүйгээр явагдана.

Хүүхдүүдэд:

- төрсөн он сар 1. 9. 2014 – 31. 8. 2015
- сургуульд орох хугацааг хойшлуулсан бол (1. 9. 2013 – 31. 8. 2014)

Огноо:

2021 оны 4-р сарын 1-нээс 30-г хүртэл

Элсэлт өгөх тодорхой он сарыг өөрийн сонгосон бага сургуулийн цахим хуудаснаас олж мэдэх боломжтой.

Хот тус бүрийн элсэлтийн бүртгэлийн мэдээлэл:

[Усти над Лабем](#) [Теплице](#) [Хомүтов](#) [Дечин](#) [Литомержице](#) [Мост](#) [Лёви](#)

Элсэлтийн явц байдал:

1. Хүүхдийг суурь боловсролд элсүүлэх өргөдлийг бөглөх (өргөдөл).
Өргөдлийг бөглөхдөө - цахимаар (зөвхөн зарим сургуульд)
 - сургуулийн цахим хуудаснаас татаж авж болно
 - сургуулиас авж болно (өмнө цаг тохирвол сайн)
2. Бөглөсөн өргөдөл дээрээ хууль ёсны асран хамгаалагч (эцэг эх) хоёулаа гарын үсэг зурсан байх ёстой.

Хэрэгтэй бичиг баримтууд:

Бүртгэлд хэрэгтэй бичиг баримтуудыг элсэлт өгөх сургуулийн цахим хуудаснаас аван боломжтой.

Сургуулиуд ихэвчлэн дараах баримтуудыг шаарддаг:

- оршин суух зөвшөөрөл эсвэл паспорт
- төрсний гэрчилгээ
- сургуульд орох хугацааг хойшлуулсан гэсэн шийдвэр (зөвхөн өнгөрсөн жилд сургуульд орохоо хойшлуулсан хүүхдүүд)
- хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч гэсэн баримт (хэрвээ эцэг эхээс өөр хүн төлөөлж байгаа тохиолдолд)

Та бичиг баримтуудаа алсаас баримтжуулж боломжтой, ердөө л энгийн хуулбар эсвэл скан хийж явуулах боломжтой.

Өргөдөл өгөх:

Өргөдлийг дараах байдлаар бүрдүүлж явуулж болно:

1. сургуулийн мэдээллийн хайрцагт (сургууль бүр өөрийн гэсэн мэдээллийн хайрцагтай),
2. цахим хаягаар хүлээн зөвшөөрсөн гарын үсэгтэйгээ (энгийн цахим зурвас илгээх боломжгүй),
3. шуудангаар,
4. биеэрээ өгөх (олон хүн цугларуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахын тулд өмнө цаг тохирч уулзалт зохион байгуулахыг санал болгож байна).

Сургуульд заавал явах хугацааг хойшлуулах

Та хүүхдээ сургуульд заавал явах хугацааг хойшлуулж болох бөгөөд үүнд та хүүхэд ээ сургуульд орохоос өмнө хүүхдийн сэтгэл зүй-хүмүүжүүлэх зөвлөгөө өгөх төв (pedagogicko-psychologickou poradnu (PPP)) дээр очих хэрэгтэй.

Хэрэв танд сурган хүмүүжүүлэх-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх төв (PPP) эсвэл тусгай сурган хүмүүжүүлэх төвөөс (speciálně pedagogického centra (SPC)) гаргасан зөвлөмж байгаа бол бүртгүүлэх үед заавал сургуульд орохыг хойшлуулах хүсэлтийн өргөдлийн хамт илгээгээрэй.

Мэдээлэл өгөх цахим уулзалт

- элсэлтийн тухай мэдээлэл
- сургууль сонгох
- сургуульд орохын өмнө хүүхдүүд юу сурсан байх ёстой вэ
- сургуульд заавал хамрагдах болон бэлтгэл ангийн
- хүүхдүүдэд зориулсан үйл ажиллагаа болон чех хэл сурах зөвлөмжүүд

Огноо:

2021 оны 3 сарын 18-ны 17:00 - 19:00 цагийн хооронд – сэдэв: Усти над Лабем хотын 1-р ангийн элсэлтийн тухай

- орчуулга өөрсдийн хүслээр

[Энд](#) бүртгүүлнэ үү.

2021 оны 3 сарын 29-ны 17:30 - 19:30 цагийн хооронд – сэдэв: Усти аймгийн 1-р ангийн элсэлтийн тухай

– монгол хэлний орчуулагчтай

[Энд](#) бүртгүүлнэ үү.

2021 оны 4-р сарын 1-ны 16:00 - 18:00 цагийн хооронд – сэдэв: Усти аймгийн 1-р ангийн элсэлтийн тухай

– орос хэлний орчуулагчтай

[Энд](#) бүртгүүлнэ үү.

2021 оны 4-р сарын 2-ны 17:00 - 19:00 цагийн хооронд – сэдэв: Усти аймгийн 1-р ангийн элсэлтийн тухай

Zápis do 1. tříd v Ústeckém kraji

– вьетнам хэлний орчуулагчтай

[Энд](#) бүртгүүлнэ үү.



FINANCOVÁNO
EVROPSKOU UNÍÍ
AZYLOVÝ, MIGRAČNÍ
A INTEGRAČNÍ FOND



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY

